



## САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2022 оны 01 сарын 26 өдөр

Дугаар 37

Улаанбаатар хот

┌ Хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох тухай ┐

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.5, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2.3, Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.2.4, Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны “Хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагаа эрхлэхэд тавигдах нөхцөл, шаардлага”-ыг батлах тухай 245 дугаар тогтоолын хавсралтын 9.6.1, 9.6.7, 9.10, 9.16 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Ашиг шинэчлэлт” ХЗХ-ны хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосугай.

2. Тогтоол батлагдсантай холбогдуулан хоршооны хадгаламж, зээлийн үлдэгдэл, бусад төлбөр тооцоог барагдуулж, оноосон нэрийн ард “Хадгаламж, зээлийн хоршоо” гэсэн дэлгэрэнгүй эсхүл “ХЗХ” гэсэн товчилсон тэмдэглэгээг хасуулж, тусгай зөвшөөрлийн гэрчилгээг Санхүүгийн зохицуулах хороонд ирүүлэх, өөрчлөн байгуулах, татан буугдах ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн дагуу гүйцэтгэж эргэн мэдэгдэхийг “Ашиг шинэчлэлт” ХЗХ /С.Одонцэцэг/-нд үүрэг болгосугай.

3. “Ашиг шинэчлэлт” ХЗХ-ны тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосонтой холбогдуулан тусгай зөвшөөрлийн гэрчилгээг хураан авч, Санхүүгийн зохицуулах хорооны бүртгэлд холбогдох өөрчлөлт хийж, тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийт болон харьяалагдах татварын алба, Улсын бүртгэлийн ерөнхий газарт ажлын 10 хоногийн дотор мэдээлэхийг Ажлын алба /Т.Жамбаажамц/-нд даалгасугай.

ДАРГА  Д.БАЯРСАЙХАН